

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ЗАХИРАМЖЛАЛЫН БАРИМТ БИЧГИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

1. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь	Үр нөлөө
1	Зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай 2017.03.30 А/171	1.Нийслэл, дүүргүүдийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны болон Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 1 дүгээр, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус олгосугай. 2.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг, түүний харьяа хэлтсүүдийн дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.	Байгууллагын хэмжээнд нэр бүхий албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэл бодож олгох тухай Газрын даргын тушаал гаргах	2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар Захиргааны хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн Ахлах түшмэл тэргүүн зэрэг, Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга Ахлах түшмэл дэд зэрэг, мэргэжилтэн Б.Сайнбаяр, Ч.Авирмэд Дэс түшмэл дөтгөөр зэрэг, У.Өнөржаргал, Б.Шатарбал Дэс түшмэл гутгаар зэрэг тус тус нэмэгдэл олгох болов.	100	Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, нэмэгдэл олгогдоно.
2	Ажлын хэсэг байгуулах тухай 2017.04.12 № А/214	1.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин, хөгжүүлэх зорилтын хүрээнд “Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай: 2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг /М.Отгонбаяр/-т даалгасугай.	“Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан, санал өгч хамтран ажиллах	Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/213, А/214 дугаар захирамжаар баталсан “Улаанбаатарт үйлдвэрлэв”, “Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөрүүдийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан, дэд хөтөлбөрийн төсөлд тусгах саналыг боловсруулан 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 02/95 дугаар албан бичгээр Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газарт хүргүүлсэн. Ажлын хэсгийн 2017 оны 04 дүгээр сарын 17, 21-ний өдрийн хуралдаанд оролцож, дэд хөтөлбөрийн төслүүдийг 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр НЗД-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар, 2017 оны 06 дугаар	100	Хөтөлбөрийн төсөлд санал тусгагдсан. /НҮИГ хариуцаж байгаа/

				сарын 22-ны өдөр НИТХ-аар хэлэлцүүлэн “Улаанбаатарт үйлдвэрлэв” дэд хөтөлбөр дэмжигдэн батлагдсан. “Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөрийг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр НИТХ-аар хэлэлцүүлэн, дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан, дахин хэлэлцүүлэхээр болов.		
3	Ажлын хэсэг байгуулах тухай 2017.07.17 № А/539	1.Нийслэлийн хүн амыг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцсэн мал, малын гаралтай бүтээгдэхүүнээр хангах зорилгоор Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт малын зах болон мах боловсруулах үйлдвэр байгуулах асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай: 2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан саналыг боловсруулан цаашид авах арга хэмжээний талаарх шийдвэрийн төслийн хамт 2017 оны 09 дүгээр сард багтаан танилцуулахыг Ажлын хэсэг /Ж.Батбаясгалан-т даалгасугай.	Ажлын хэсгийн удирдамж, төлөвлөгөө боловсруулан батлуулах	Малын захыг мах боловсруулах үйлдвэрийн хамт хотын зүүн, баруун бүсэд байгуулах бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, удирдамж батлуулсан. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд "МБУ Трейд" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Малын зах байгуулах газрын байршлыг Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 11 хорооны нутаг дэвсгэрт 21.2 га газрыг Засаг даргын А/516 тоот захирамжаар шийдвэрлүүлэн "МБУ Трейд" ХХК-тай газар ашиглуулах гэрээг байгуулан хамтран ажиллаж Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын баталсан зураг төслөөр ажлыг гүйцэтгэж эхлүүлээд байна.	100	Нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй мах болон махан бүтээгдэхүүнээр хангах боломж бүрдэнэ.
4	Хөрөнгө гаргах тухай 2017.09.05 № А/662	1.Монгол Улсад худалдааны салбар үүсч хөгжсөний 96 жилийн ойн хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байгаа “Улаанбаатар түншлэл-2017” олон улсын үзэсгэлэнгийн зар сурталчилгааг олон нийтэд хүргэх, амжилттай оролцсон иргэн, аж ахуйн нэгжүүдэд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит шагналыг гардуулах ёслолын ажиллагааг өндөр хэмжээнд зохион байгуулахыг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Д.Баянбат/, Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар /Б.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.	Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар, МҮХАҮТ-тай хамтран үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	Захирагчийн ажлын алба, Гэрэлтүүлэг чимэглэл ХК-тай хамтран “Улаанбаатар түншлэл-2017” Олон улсын үзэсгэлэн, худалдааны зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж, Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар, МҮХАҮТ-тай хамтран 09 дүгээр сарын 07-оос 10-ны өдрүүдэд “Мишээл Экспо” төвд зохион байгуулсан. Үзэсгэлэнд хүнс, хөнгөн, гоо сайхан, жижиг, дунд үйлдвэрлэлийн дотоодын нийт 60 гаруй, ОХУ, Пакистан, Тайван зэрэг улсаас нийт 12 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид оролцож, шинэ бараа бүтээгдэхүүнээ танилцуулан, нийт 150 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	100%	Үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн дотоодын зах зээлд сурталчлагдаж, бизнес эрхлэгчид хоорондын түншлэлийн хамтын ажиллагаа өргөжнө.

5	Гадаад томилолтын тухай 2017.09.22 № А/702	3.Томилолтоор ажилласан тухай тайланг ирсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Д.Баянбатад даалгасугай.	“Монгол, Хятадын 2 дахь удаагийн экспо” арга хэмжээнд оролцох хамтран зохион байгуулах, туршлага судлах, тайлан хүргүүлэх	2017 оны 09 дүгээр сарын 25-28-ны өдрүүд “Монгол, Хятадын 2 дахь удаагийн экспо” арга хэмжээнд оролцлоо. “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-ын хүрээнд 2 улсын анхны экспо 2015 онд Хөх хотод амжилттай зохион байгуулагдсан бөгөөд энэ удаагийн экспо улам өргөжиж, Монгол Улсаас төр, хувийн хэвшлийн 1600 гаруй төлөөлөгчид оролцсон. НЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтэст 2017.12.05 өдрийн 01/426 албан бичгээр гадаад харилцааны тайланд тусган хүргүүлсэн.	100	Тус хотын хөдөө аж ахуй, эдийн засаг, үйлдвэрлэл, хот тохижилт зэрэг байгууллагын удирдлагуудтай уулзаж хамтарч ажиллах
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					100%	

Биелсэн:5
 Хэрэгжих шатанд:0
 Хугацаа болоогүй:0
 Тасарсан:0
 Үнэлгээгүй ажил:0

2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь	Үр нөлөө
1	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2017.11.09-ний өдрийн 37 дугаар хуралдааны тэмдэглэлд:	<p>- Орон зайн дундын мэдээллийн сангийн өгөгдөл боловсруулахаар ажиллаж байгаа Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд мэдээ мэдээллээ цаг тухай бүр шуурхай оруулж байхыг Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад;</p> <p>- Орон зайн дундын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлэлт, боловсруулалтанд хяналт тавьж ажиллахыг НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Өлзийбаяр /Дундын мэдээллийн сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга/-т</p> <p>- Нийслэлийн орон зайн дундын мэдээллийн сангийн танилцуулга цаашид авах арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг тусган “Гео мэдээллийн системийн хяналт, судалгааны нэгж” байгуулах асуудлыг судалж эргэн танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга /М.Отгонбаярт/-т үүрэг болгов” гэжээ</p>	Нийслэлийн дундын мэдээллийн сангийн өгөгдөл боловсруулах сургалтад хамрагдаж, Нийслэлийн дундын мэдээллийн сангийн өгөгдөлд оруулах боломжтой мэдээллийг тодорхойлолх	Нийслэлийн Засаг даргын А/864 дүгээр захирамжийн дагуу "Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн нэгдсэн тогтолцоог бий болгох" ажлын хүрээнд байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас дундын мэдээллийн сангийн өгөгдөлд Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх бүсийн мэдээллийг бэлтгэн оруулсан. Одоо нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн байршил болон хүлэмжийн байршилыг тус тус бэлтгэн орууллахаар ажиллаж байна.	70	Иргэд төрийн мэдээллийг шуурхай авах нөхцөл бүрдэнэ.
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					70	

Биелсэн:
Хэрэгжих шатанд:1
Хугацаа болоогүй:
Тасарсан:
Үнэлгээгүй ажил: